

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Дэлгэрцогт сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/21 тоот захирамжийн дагуу сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт дор дурьдсан байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулахаар зарлаж байна.

1. **Дуудлага худалдааны хэлбэр:** Цахим хэлбэрээр Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу дараах байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдаа явагдана.

2. **Дуудлага худалдааны ерөнхий зүйл:**

№	Газрын байршил	Зориулалт	Талбайн хэмжээ, м ²	Эзэмшүүлэх газрын суурь үнэ, төг	Эзэмшүүлэх хугацаа, жилээр	Эзэмшүүлэх нэгж талбарын тоо
1	3-р баг, Засмал замын зүүн талд Хаданхошуу	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл үйлчилгээ	2203 /0,22 га/	1.057.440	15	1

3. **Эзэмшүүлэх газрын тойм зураг**



Координат:

- 1. 607072.9350 5108616.6300
- 2. 607126.6690 5108616.9830
- 3. 607127.7480 5108576.7000
- 4. 607071.4440 5108576.8310



- Дуудлага худалдаагаар олгох газар

4. **Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа:** Дуудлага худалдаанд оролцогчдыг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 09 цаг 00 минутаас эхлэн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 08 цаг 30 минут хүртэл [цахимаар mle.mn](http://цахимаар.mle.mn) хаягаар бүртгэнэ.

5. **Дуудлага худалдаа явагдах хугацаа:** Цахимаар 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 09 цаг 00 минутад эхлэнэ.

6. **Дэнчингийн хэмжээ:** Дуудлага худалдааны анхны үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

7. **Дуудлага худалдааны өсгөн дуудах үнийн хэмжээ:** 100 000-500 000 /нэг зуун мянган төгрөгөөс таван зуун мянган/ төгрөг

8. **Дуудлага худалдаанд ялагчийг тодруулах журам:** Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогч ялагч болох бөгөөд ялагч нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлж, дэнчин болон улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн, өөрийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварын тухай мэдээллээ үнэн зөв гаргасан, дуудлага худалдааны дэг журмыг зөрчөөгүй байна.

9. **Дуудлага худалдаанд оролцогч дараах материалыг бүрдүүлнэ:**

9.1. Иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

9.2. Дэнчингийн мөнгө төлсөн баримт /Дуудлага худалдааны анхны үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү/

9.3. Өөрийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварыг үнэн зөв тодорхойлсон банкны тодорхойлолт

9.4. Дуудлага худалдаанд иргэнийг төлөөлж оролцох тохиолдолд тухайн иргэний олгосон нотариатчаар гэрчлүүлсэн итгэмжлэл

9.5. Дуудлага худалдаанд аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж, оролцох тохиолдолд тухайн аж ахуй нэгж, байгууллагын олгосон итгэмжлэл

Жич: 1. Цахим дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд дуудлага худалдааны зард заасан хугацаанд дээрх материалыг бүрдүүлж, **mle.mn** цахим хуудсанд хандан хүсэлтээ гаргана.

2. Хүсэлтийг хүлээн авч, дуудлага худалдааны оролцогч болсныг цахим дуудлага худалдаа явуулах тусгай програм хангамжид нэвтрэх нэр, нууц үгээр баталгаажуулж оролцогчид мэдэгдэнэ.

Холбоо барих утас: 80004597

2020.02.18.